



# ДЭГДЭЭХЭЙ ХАМГААЛАГЧ ХҮҮХАУУД



Редактор: Г. Ганчулуун  
Зохиолч: А.Найгаль  
П.Наранбаатар  
Зураач: Б. Аюурзана  
Б. Бадамханд  
Гүйцэтгэсэн: Вайрал Партнерс ХХК

Хавар. Их талд захаасаа хайлмагтаж буй цасан дороос яргуй цухуйхтай зэрэгцэн төлийн дуу цангинах нь малчин Жадамба, эхнэр Сэндэмийн сэтгэлийг баясгана.



Жадамбых Мэргэн,  
Есүгэн гэдэг хоёр  
хүүхэдтэй.







Харин тиймээ хө,  
манай хоёр ч ажилтай  
шүү, ажилтай. Мал  
төллөх үеэр сурагчдын  
амралт урт байх нь  
сайхан юм.




Миний охин гүйгээрэй!










Тэнгэрт урд зүгээс шувуудын түрүүч ганганалдан ирэв. Хүүхэд хөгшидгүй л бөөн баяр.







Үгүй ер ямар улс гэхээрээ ийм юм идэж уудаг байна аа. Сайхан шөл устай хоол идэхгүй, ийм юм идэж ууж суух гэж.



Эгчийн энэ хоёр ч хонь мал хариулж бидний ажилд туслах нь юу л бол. Энэ мотоциклоо унаад уул даваад алга болно биз...







Хань аа!  
Энэ хүүхдүүдийн унаа нэг л биш шүү.




Харин тийм ээ!









Тэмүүлэн, Тэлмүүн хоёр нуурын захаас нэлээн алс доvны орой дээр оччихсон Тэлмүүн ах нь хөгжмөө эцэс дээр нь тавин, Тэмүүлэн өндөг хальслан идэж байв.






Та хоёр чинь яаж байгаа юм бэ! Наад чанга хөгжим чинь хавийн шувуудыг үргээгээд дууслаа. Өө, энэ өндөгнүүд арай, арай!



Яалаа! гэж дүү минь. Бид ч бас тийм яахаа алдсан хүүхдүүд биш шүү. Тэгээд ч тахианыг өндөг идэж байна!



Тийм байлгүй дээ. Уучлаарай ахаа, эгчээ. Би буруу боджээ. Нуур амгалан бол шувууд амгалан гэж аав хэлдэг болохоор л...

Та хоёр цэн тогоруунд үнэхээр хайртай юм.



Хайрлахгүй байхын аргагүй шүү дээ. Өндгийг дэгдээхий болтол бүр нисч суртал нь хамгаалахгүй бол үхэх эрсдэлтэй.



Айн, яагаад?



Тийм эмзэг байдаг юм уу?





Хэрвээ тогоруу дэгдээхэйгээ алдвал уйтгар гунигт автдаг гэнэ лээ. Өндөг байсан газраа эргэлдээд л ёстой өр өвдмөөр гэж аав ярьсан.

Эвий дээ, хөөрхий амьтад. Яг л хүн шиг юм байна. Ер нь хэдүүлээ эндээс холдъя. Мотоциклийн дуунд цочоод айсан байх даа.



Та хоёр мотоцикл унаж үзэх үү?







Тэгье, тэгье!




Юу гэнэ ээ, салхинд юу ч сонсогдохгүй байна аа.

Аавын мотоциклоос хурдан юм байна.





Амралт дуусаж, зочид буцаж, хүүхдүүд сургуульдаа явах боллоо.



Сайхан амраасанд баярлалаа. Сайн сууж байгаарай.


Зүгээр дээ, хэд хоног ч гэсэн агаарт байдаг сайн хүүхдүүд шүү та хоёр.



Ээжээ, ах бид хоёр ч гэсэн сайн хүүхдүүд биз дээ?

Үгүй ээ тэр... Сайнаар барах уу, та дөрөв дөрвүүлээ л сайн шүү дээ. За та хэд минь болгоомжтой яваарай.

Ээжээ дэгдээхэйг минь сайн хараарай.




Тэд сумын төв дээр ирцгээжээ.



Баярлалаа, баяртай.



Зуны амралтаар заавал ирээрэй.



Тэгэлгүй яахав. Аав ээж хоёр зөвшөөрвөл заавал ирнэ ээ.




Баяртай, сайн яваарай!



Миний хоёр хүүхэд хичээлдээ сайн шамдаарай. Бусадтай эвтэй байгаарай.


Зуны эхэн сарын сүүл.  
Сурагчдын зуны амралт  
хэдийн эхэлжээ.




Жадамбынх зусландаа бууж хажууханд нь  
гадаад хэдэн хүмүүс ирсэн нь Монгол  
дагуур, Улз голын орчимд шувуу ажиглах  
судлаачид байв.


Шувуудын зургийг авч дараа нь  
компьютер рүү хуулан нэг бүрчлэн үзэж,  
хоорондоо Англиар ярилцах гадаад  
хүмүүсийг Мэргэн үргэлж дагана.








Зуны халуун өдөр Динго нуур руу зүглэж  
явах нь харагдав.



Аав аа, ээж ээ!  
Урд айлын  
Динго дэгдээхэй  
барих нь...




Аав аа, хурдан гүйгээрэй...  
хурдлаарай...




Динго халууцаад л ус руу  
орсон байна шүү дээ.  
Ёох бүр амьсгаадчихлаа.



Сүүлийн үед сумын төвд нэг муур гарч ирээд айлуудын тахиа, шувууг шоглож, байнга үймээн тарьдаг болжээ. Хаанаас, яаж ирсэн нь тодорхойгүй ч магадгүй эзэн нь амралтаар авчирсан байж мэднэ.







Өдөр, хоног өнгөрсөөр. Манай хоёр ч бас нуурын эргэн тойрон сахиж, дэгдээхэйд учирч болох аюулаас сэргийлнэ.



Ахаа, нуур руу адуунууд орох нь ээ, дэгдээхэйг минь гишгэчих вий дээ...

Хоёулаа адууны чигийг өөрчилж, зэгснээс холуур нуур руу тууя.



Зуны амралтаараа амьтан, ургамал таних аялалаар яваа олон хүүхдүүд Жадамбын гэрийн ойролцоо буужээ. Тэдний багш гэж тун сайхан зантай нэг ах ирж. Тэр хүнийг Зундуй гэдэг.



Хүүхдүүд ээ, амрагч, малчдад цэн тогоруу болон нутгийн шувуудын тухай сонирхолтой мэдээлэл өгч, байгалиа хэрхэн хамгаалах талаар хичээл орцгооё.



Тэгье.

Тэгье.


Зундуй ахаа багш нь Мэргэн, Есүгэн хоёр байвал болох уу?



Үнэхээр сайхан санаа байна. Зөвшөөрч байна уу, Мэргэн, Есүгэн?



Ах дүү хоёр хүмүүст хэрэгтэй мэдээлэл өгөх ялангуяа цэн тогорууны тухай, шувуудын тухай, хүмүүст ярьж өгнө гэхээр сэтгэлд нь их л таатай санагдсан тул саналыг хүлээн авлаа.







Олны өмнө гарах тул хичээлээ бэлдэх, үг хэлээ цэгцлэх, хувцас хунараа бэлдэх, хичээл заах танхимдаа цэвэрлэх гээд ажил мундсангүй.






Лайла цонхоор үсэрч, Динго хаалга руу гүйхэд Есүгэн тэднийг торонд түр түгжив.












Багшаа, дэгдээхэй өндөгнөөсөө гараад юу иддэг юм бол? Би талх, будаа өгч болох уу?




Дэгдээхэй шавж, хорхой, ургамлын үндэс, нахиагаар хооллодог. Хэрвээ бид талх, будаа өгөх гээд ойртвол тэд үргэнэ, айна.



Байгаль дээр тэдний идэх хоол зөндөө бий. Тогоруу үржлийн үедээ мэлхий, загас, том хорхой шавжаар хооллодог.



Хөөх, мэлхий, загас иддэг байх нь ээ...





Цэн тогорууг Азийн орнуудад тэр дундаа Япон, Солонгос, Хятадад урт нас, амжилт, хөгжил цэцэглэлт, аз хиймөр гээд сайхан бүхний бэлгэдэл болдог шүү.



Манай зарим сумынхан цэн тогорууг "Азын шувуу" гэдэг бөгөөд хосоор нь харвал ихэд бэлгэддэг юм.

Тийм шүү, тийм, Үнээн үнэн.




Японы уламжлалд "1000 тогорууны оригами" хийвэл хүсэл биелнэ гэдэг юм билээ.


Оригами гэдэг чинь цаасан урлал бил үү?

Өнгийн цаасаар нугалж хийдэг. Цаасан урлал.


Аан за за.








Сумын сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт болж байна. Зуны амралтаа зугаатай өнгөрөөсөн хүүхэд багачууд нэгнээ санасан ч гэж жигтэйхэн.



Хүүхэд багачууд,  
багш сурган хүмүүжүүлэгч та  
нартаа хичээлийн шинэ жилийн  
мэнд хүргэе.



Баярлалаа, захиралаа. Одоо эрхэм  
зочид, багш, сурагчид та бүхэнд нэгэн  
таатай мэдээг дуулгая!  
Сургуулийн урлаг зааланд "Цэн  
тогорууд" нэртэй үзэсгэлэн албан  
ёсоор нээгдлээ. Та бүхнийг таалан  
сонирхохыг урьж байна.








Намайг Есүгэн гэдэг би энэ жил 4-р ангид орно. Ноднингоос хойш нутагтаа ирж зузаж буй цэн тогоруудын өдөр бүрийн амьдрал, хийж буй үйлдэл, зан араншингийн тухай тэмдэглэл хөтлөх болсон...



Баярлалаа. Олон өдрийн тэмдэглэлээс цөөхөн хэдийг нь л үзэсгэлэндээ зориулан дэлгэсэн шүү.



05 сарын 05


Өглөө эрт бослоо.


Ээжид тугал татаж өгчихөөд хонио бэлчээхээс өмнө аавын дуранг авч хойд довон дээрээс нуурын баруун биеээр нутагтай Цэн тогорууны гэр бүлийнхэнийг баахан дурандлаа.

Цэн тогорууны нэг нь идэш хоол олж ирэхээр явсан бололтой харагдсангүй. Нэг нь өндөгөө дараад их л ажилтай байгаа бололтой.

Энэ үед манайх болон, саахалтын айлууд нэг хэсэгтээ нохойгоо уяанаас нь ер тавиагүй билээ.

Юмыг яаж мэдэх вэ тэнд өндөг дарж буйг ноход очоод айлгаж орхивол яана гэж болгоомжилсон юм.






06 сарын 05


Бүрхэг өглөө юмаа. Дахиад довон дээр гарч Цэн тогоруудыг дурандлаа. Хоёр том тогоруу хоёр дэгдээхэйгээ дагуулан тонголзон явна.

Гэтэл сонин юм ажиглагдлаа. Нуурын хөвөөгөөр хэн нэгэн эдний уурыг хүргэв үү...

Хоёр цэн тогоруу далавчаа байдгаараа дэлгэн ямар нэгэн амьтаныг элдэн хөөж байна. Үнэг хярс ч байж мэднэ.

Дэгдээхэйд хөнөөлтэй амьтад олон билээ.






07 сарын 05

Тунгалаг сайхан өглөө. Наадам ч ойртжээ. Тээр тэнд улаан тоос босно. Хүмүүс уралдааны морьдоо тарлаж хөлсөлж буй бололтой.

Ойрд бид Банхар нэртэй нохойгоо, айлууд ч, нохдоо дандаа уяатай байлгаж байгаа. Учир ноу хэмээвээс нуурын цаадах тэгш талбайд уралдаж буй морьд руу манайханы ноход сэтгэл нь хөдлөөд уралдан давхиж хүрэх замдаа тогорууны хоёр дэгдээхэйг санамсаргүй айлгаж орхивол яана гээд л бүгд болгоомжилж нохойнуудаа наадам өнгөртөл уяанд оруулсан билээ.

Түүнээс миний хөөрхөн Банхар, саахалт айлын ноход хэзээ ч санаатайгаар дэгдээхэйнүүдийг очоод айлгаж, үргээж, гэмтээхгүй ээ.




Ирсэн зочдын зарим нь инээж зарим нь гунигласан царай гарган уншицгаана.



Энэ бол зөвхөн үзэсгэлэн биш,  
байгалиа хайрлах сэтгэлээ хүмүүст  
хүргэх гэсэн хүүхдүүдийн оролдлого.  
Мэргэн, Есүгэн хоёр шиг олон хүүхэд  
эх дэлхийнхээ төлөө өөрийн чадах  
бүхнээ хийж байгаад баяртай байна.

Хүмүүс алга ташин талархлаа  
илэрхийлж, хүүхдүүдийн бүтээлийг  
шимтэн сонирхож байлаа.





Цэн тогорууд ирлээ  
Цэнхэр тэнгэртээ зэл татуулан  
Цээлхэн дуугаар хөг нэмэн  
Цэнгэл баяртай ганганалдан ирлээ


Хүн, амьтны хөлөөс хол  
Нуурийн эргийн зэгсэн дунд  
Үүр гэрээ тэд заслаа  
Өндөгөө гаргаад удаан дарлаа

Хатуу хальс хагарах дөхөж  
"Том болсоон, гаръя" гэх шиг  
Дотроосоо тог тог тогшоор  
Толгой нь түрүүлээд гараад ирлээ



Зулай нь нойтон сониуч дэгдээхэй  
Зүггүй салхинд далавчаа дэвнэ  
Зэгст нуураа харж баясана  
Зэллэн нисэхэд хичээн суралцана

Цэн тогорууд буцлаа  
Цэнхэр тэнгэртээ зэл татуулан  
Цээлхэн дуугаар хүч нэмэн  
Гунганан, ганганан алсыг зорьлоо.






За Мэргэндээ баяр хүргэе.  
Дүүтэйгээ хамтран  
үнэхээр сайхан үзэсгэлэн  
гаргасан байна.




Гарын үсгээ  
зураад өгөөч.





Дин Динн






Хараач! Тогоруу буцаж байна.



"Баяртай хүүхдүүд ээ", баяртай. Эх болсон байгаль дэлхийгээ хайрлаж яваарай! Ирэх жилийн хавар уулзацгаая...



Сайн яваарай, баяртай, баяртай!

# Намайг будаарай!



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН  
(WWF)-ГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО НЬ  
ЭХ ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ДОРЙТЛЫГ ЗОГСООЖ, ХҮН ТӨРӨЛХТӨН  
БАЙГАЛЬТАЙГАА ШҮТЭЛЦЭН АМЬДРАХ  
ИРЭЭДҮЙГ БҮТЭЭХЭД ОРШИНО.



Working to sustain the natural  
world for the benefit of people  
and wildlife.

together possible . [panda.org](http://panda.org)